



ГОВЬСҮМБЭР АЙМАГ  
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 08 сарын 26 өдөр

Дугаар А/133

Шивээговь сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Сумын Онцгой комиссын 2021 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн 42 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Сумын Эрүүл мэндийн төвийн түргэн тусламжийн авто машинд шаардлагатай сэлбэг худалдан авахад зарцуулагдах 800000 (найман зуун мянга) төгрөгийг зарцуулсугай.

2. Авто машины сэлбэгийг худалдан авахад шаардагдах 800000 (найман зуун мянга) төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангийн гамшгаас хамгаалах зардлаас гаргахыг нягтлан бодогч (Б.Энхмаа)-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж, санхүүгийн баримт бичгийн бүрдлийг ханган ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Отгонжаргал)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



П.ГАНЧИМЭГ